

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож тэмдэглэгээ хийх (✓)			
		Тулгамд-сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэхээр “Тогтоолд өөрчлөлт оруулах” тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох тооцооны хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 1/110 тоот албан бичгээр холбогдох яамдаас санал авч, ЗГХЭГ-т 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 1/216 тоот албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.		✓		
2.	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд тусгах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн боловсруулж Эдийн засаг хөгжлийн яаманд 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/180 тоот албан бичгээр хүргүүллээ.			✓	
3.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын гишүүдэд танилцуулах зорилгоор холбогдох тооцоо судалгаа, илтгэл мэдээллийг бэлтгэн нэгдүгээр сарын 3-5 өдрүүдэд Төрийн ордны Жанжин Сүхбаатарын танхимд хэлэлцүүллээ. Түүнчлэн гишүүдийн асуултуудад тодруулга мэдээлэл өгч, нэмэлт тооцоо судалгааг бэлтгэн ажиллав.		✓		
4.	“Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, тэмдэглэлийн төсөл болон холбогдох тооцоо судалгааг боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/240 тоот албан бичгээр яамдаас санал авахаар хүргүүлээд байна		✓		
5.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийн чадавхийг бэхжүүлэх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 1 дүгээр сарын 17-ны өдрийн 33/136 албан бичгээр хүргүүлэв.			✓	
6.	Орлогыг орлуулан тооцох аргаар амьжиргааны түвшин тогтоох судалгааны үзэл баримтлал, шинэчилсэн аргачлал, судалгааны маягт, маягт нөхөх зааврын төслүүдийг эцэслэн боловсруулж, ҮСХ-той хамтран батлахаар албан бичгийг хүргүүлэхэд бэлтгэв.			✓	
7.	Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, Олон Улсын туршлагын талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, гишүүдэд өгөв.		✓		
8.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Маягт, заавар баталж мөрдүүлэх тухай” А/02 дугаар тушаалыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхээр 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/109 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.			✓	
9.	Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу ногдуулж буй ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. Тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авсан.			✓	

	Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлэн, албан ёсоор ёсчилохыг хүлээж байгаатай холбогдуулан уг тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудал түр хойшлон, хүлээгдэж байна.				
10.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн Сайдаар батлуулахаар хүргүүлэв.			√	
11.	Хүүхэд хамгааллын хуулийн төслийг боловсруулж яамны сайтад байршуулж, санал авч байна. Төслийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлэх уулзалтыг 2 удаа зохион байгуулж, төсөлд 5 яамны саналыг тусгаад байна.			√	
12.	Нийгмийн ажлын талаарх бодлогын баримт бичиг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах тухай тушаалын төслийг боловсруулсан.			√	
13.	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулах УИХ-ын НББХ-ны ажлын хэсэгт ажиллав. Тогтоолын төслийг УИХ-ын 2022 оны 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлав.		√		
14.	Ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны төлөвлөгөө батлах тухай 2 сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан ЭМ-ийн сайдад хүргүүлэв.			√	
15.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт батлах тухай" 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220, А/475, А/812 хамтарсан тушаалд нөлөөллийн шинжилгээ хийж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5689 дугаарт бүртгүүлэв.			√	
16.	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай" 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5690 дугаарт бүртгүүлэв.			√	
17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг төрийн бус байгууллагын төлөөлөлд эцэслэн хэлэлцүүлж, саналыг тусгав.			√	
18.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг Даргын тамгын газар, Стандарт хэмжил зүйн газар зэрэг холбогдох төрийн байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлж, саналыг тусган ажиллаж байна.			√	
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
19.	Нийгмийн халамжийн сангийн 2021 оны төсвийн зарцуулалт, Коронавируст халдварын цар тахал (Ковид-19)-ын үед иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэмжээг нэмэгдүүлэн олгосон нийгмийн халамжийн үйлчилгээний хамрагдалт, зарцуулсан хөрөнгийн талаархи мэдээллийг бэлтгэн удирдлагуудад танилцуулав.			√	
20.	Хүүхэд хамгааллын салбар дундын ажлын хэсгийн төлөвлөгөөний төсөл боловсруулав.			√	
21.	Хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн шинэчлэл хийх ажлын хэсэг байгуулж дүрэм журмыг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.			√	
22.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Монголын ахмадын холбооны хооронд төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах 2022 оны гэрээг 2022 оны 01 сарын 21-ний өдөр байгуулав.			√	
23.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төсөлтэй хамтран 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хооронд үндэсний хэмжээнд "Хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалт нь 6 аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд ажиллах хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчийн хүний нөөцийн болон сургалтын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой. Энэ оны 01 дүгээр сард нийт 8 удаагийн сургалт зохион байгуулж, нэг удаагийн сургалтад 100-120 хүн хамрагдав.			√	
24.	ХНХ-ын дэд сайдын ахалсан нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоох, чанар хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлт боловсруулан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт			√	

	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлт, тусламж авах эрхтэй холбоотой орсон өөрчлөлтүүдийн талаар танилцууллаа. Мөн нийгмийн халамжийн бодлогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих тухай олон улсын туршлагын мэдээллийг бэлтгэв.				
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
25.	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тоот тушаалыг батлуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.			√	
26.	Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийн тандан судалгааг өргөжүүлэн гадаад улс орнуудын туршлагыг орчуулж, нэмж тусгав.			√	
27.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.5-ын 3-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэврийн зөрүүг ойртуулах, тэтгэвэр нэмэгдүүлэх тооцоо, судалгаа, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/211 дүгээр тушаалаар баталсан. Энэ ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас холбогдох судалгаа, тооцоолол болон санал авч, тэтгэврийг нэмэгдүүлэх талаар 8 хувилбар бүхий танилцуулга, санал боловсруулав.			√	
28.	Нийгмийн даатгалын улсын /ахлах/ байцаагчийн эрх түдгэлзүүлэх тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын ...-ны өдрийн А/... тоот тушаалын батлуулж, хэрэгжилтийг зохицуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.			√	
29.	Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5/А/04 дүгээр хамтарсан тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд зарцуулсан хөрөнгийн тооцоо нийлэх, холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг батлуулав.			√	
30.	Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 251 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг тогтоох” талаарх холбогдох мэдээллийг хүргүүлэв.		√		
31.	“Малчдын нийгмийн хамгааллыг өргөтгөж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хийгдэх “Малчдад зориулсан мэдээллийн технологийн шийдэл” системийн ажлын даалгаврыг Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллаж санал хүсэлтийг солилцох хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 14-нд Нийгмийн даатгалын ерөнхий газарт зохион байгуулав.			√	
32.	“Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга зам” сэдэвт уралдаанд ирүүлсэн материалыг сонгон шалгаруулах хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 14-нд зохион байгуулав.			√	
33.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настны үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөлийн хуралдааныг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран зохион байгуулав.			√	
34.	2022 онд протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлчилгээг үзүүлэх байгууллагын жагсаалт үүсгэх зорилгоор байгууллагуудад тавигдах нийтлэг болон тусгай шалгуурыг боловсруулан батлах ажлын хэсэгт тус газрын мэргэжилтнүүд оролцон ажиллаж шалгуурыг батлан, ХХҮЕГ-ын цахим хуудсаар оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж байгууллагуудад урилгыг нээлттэй байршуулан материалыг хүлээн авахаар ажиллаж байна.			√	
35.	Ахмад настны үндэсний төвийн орон тооны бүтцийг шинээр боловсруулан Сэргээн засах сувиллын чиглэлээр магадлан итгэмжлэлд оролцон ЭМД-ын сангаас санхүүжилт авах эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд тус төвтэй хамтран бүтцийн төслийг боловсруулж байна			√	
36.	Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопед, тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг шинэчлэн баталсантай холбогдуулан Хараагүйчүүдийн тусгай хэрэгслийн хөнгөлөлтийн хэрэгжилтийн байдал, цаашид шийдвэрлэх асуудлын талаар Монголын хараагүйчүүдийн			√	

	үндэсний холбоотой хамтран ТВ8 телевизийн “Чухал сэдэв” нэвтрүүлэгт оролцон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл хүргэв.				
37.	УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, Төрөлжсөн асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын хийх мэдээлэл, танилцуулгыг бэлтгэв.			√	
38.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, холбогдох хуулиудын шинэчлэлийн төсөлд Төрийн бус байгууллагуудын саналыг тусгах хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр цахимаар зохион байгуулав. Мөн ажлын хэсгийн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан ажлын хэсгийн ахлагч ХНХ-ын дэд сайд С.Зулпхарт танилцуулав.			√	
39.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжилтийн талаар байгуулах гэрээний төсөл болон хавсралтад нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээний /ОНОТХУ, Асрамжийн үйлчилгээ, Хүнсний талон, Нийтийн тээврээр зорчсоны төлбөр/ санал, халамжийн хөтөлбөрүүдийн тоон болон чанарын үзүүлэлт, төсвийг хянан холбогдох газарт хүргүүлэв.			√	
40.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас үзүүлэх зарим төрлийн үйлчилгээ тэдгээрийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2022 оны төлөвлөгөөнд тусгуулан гүйцэтгүүлэх зорилгоор уулзалт зохион байгуулж, судалгааны арга зүй, аргачлалыг хамтран боловсрууллаа. /протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх судалгаа/			√	
41.	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай" 2018 оны А/69/48 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтад заасан "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт"-ыг "Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/758/А/197 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан өвчний оношийн жагсаалтад байгаа "хугацаагүй" гэж заасан өвчний оноштой нийцүүлж, мөн ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөлийн дарга нараас цахимаар санал авч өөрчлөлт оруулан ЭМЯ-нд хүргүүлэв.			√	
42.	Азийн хөгжлийн банкны ТА-9893 төсөл болон Судалгааны институт хамтран “Хүнсний эрхийн бичгийн” үйлчилгээний хэрэгжилтийн судагааны үнэлгээний тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын удирдлагуудад танилцуулав.			√	
43.	Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” А/223 дугаар тушаалыг хүчингүй болгов. Ингэснээр Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу гадаадад ажиллах хүч гаргахтай холбоотой арга хэмжээг хэвийн үргэлжлүүлэх боломжтой боллоо.			√	
44.	Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөр, арга хэмжээг боловсронгуй болгон шинэчилж, мөн ногоон ажлын байр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2 шинэ хөтөлбөрийг нэмж боловсруулан нийт 7 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.			√	
45.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж байна.			√	

46.	Тус яамнаас Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай 2021 онд байгуулсан “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа” хийх тухай 40329951/0 дугаар гэрээний тайланг гарган ОУХБ-д хүргүүлэв.			√	
47.	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө”-нд тусгах саналыг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэв.			√	
48.	“ХАБЭА-н үндэсний хорооны 2022 оны ажлын төлөвлөгөө”-ний төслийг нэгтгэн боловсруулав.			√	
49.	“Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар Шадар сайдад хүргүүлэв.			√	
50.	Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 тоот тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар холбогдох тооцоо судалгааг хийж байна.			√	
51.	“Цалин хөлс тооцох аргалчлал”, “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”, “Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлал”, “Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал”-ын төслүүдийг боловсруулан Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос санал авахаар хүргүүлж, ирүүлсэн саналын хүрээнд холбогдох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.			√	
52.	“Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”, “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм”-ийн төслийг боловсруулан Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос санал авахаар хүргүүлэв.			√	
53.	Төрийн өндөр албан тушаалтны цалин хөлстэй холбоотой тогтоол, шийдвэрт холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тооцоо, судалгаа хийж хууль тогтоомжийн төсөл боловсруулав.			√	
54.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдуудаас санал авахаар хүргүүлэв.			√	
55.	“Хамтын гэрээ хэлэлцээр бүртгэх мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ыг боловсруулан ХНХ-ын сайдаар батлуулж, хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлэв.			√	
56.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны хурлыг хуралдуулах бэлтгэл ажлыг хангаад байна.			√	
57.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны дүрмийн төслийг боловсруулан яамдаас санал авч нэгтгэн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.		√		
58.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын захирамжаар батлуулав.		√		
59.	ХНХЯ, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, санал авч байна.			√	
60.	Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчийн анхдугаар чуулганыг зохион байгуулах талаар холбогдох төсөл боловсруулж байна. Салбар дундын ажлын хэсэг байгуулах, чуулган зохион байгуулах ажлын удирдамжийн төслийг боловсруулаад байна.			√	
61.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А /209 тушаалаар баталсан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”, 2021 оны А /210 тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”, 2021 оны А /218 тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын эрх зүйн мэдээллийн санд			√	

	бүртгүүлсэн ба батлагдсан дүрэм, журмыг үндэсний хэмжээнд дагаж мөрдөх арга зүйн зөвлөмжийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.				
62.	ЗГХА-Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хуулийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл хугацаатай үүргийг албан бичгээр өгч хүргүүлсэн.			√	
63.	Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам шинээр байгуулагдсантай холбогдуулан “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай төслийг боловсруулан Ерөнхий сайдын ахлах зөвлөхөд хүргүүлэв.		√		
64.	Хүүхдийн эрхийн тухай конвенц 6 болон 7-р дугаар тайлан, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай албан бичгийг ХНХ-ын сайдын 2022.01.25-ны өдрийн 1/200 тоотойр яамдад хүргүүлэв.			√	
65.	Хөдөлмөрийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг холбогдох заалтыг хэрэгжүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудад хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлийг ХНХ-ын сайдын 2022.01.21-ний өдрийн 1/173 тоот албан бичгээр хүргүүлэв.			√	
66.	“Хүүхдийн эрхийн эрхийн улсын байцаагчдын 2022 оны төлөвлөгөөт хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г ХНХ-ын сайдаар батлуулж, ХНХ-ын сайдын 2022.01.19-ний өдрийн 03/154 тоот албан бичгээр ГБХЗХГ-т хүргүүлэв.			√	
67.	“Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслан байгуулах ажлын хүрээнд: <ul style="list-style-type: none"> - Салбар дундын ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслангийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулав. - “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зураг төсвийг хийж гүйцэтгэгч "MSL" ХХК компанитай мэдээлэл солилцох уулзалт хийв. - “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги боловсруулах тушаалын төслийг боловсруулав. Монгол Улсын Ерөнхий сайдад батлуулахаар “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зусланг байгуулах талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн хүргүүлэв.		√		
68.	Нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүйн үндэсний хорооны хурлыг ойрын үед зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.			√	
69.	Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж, тогтвортой байдлыг үнэлэх ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/113 дугаар тушаалын дагуу НҮБ-ын хүн амын сан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хамтран бүсчлэн зохион байгууж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөр, төвийн үлгэрчилсэн дүрмийн хэрэгжилтийг үнэлж, санаачилгатай, бүтээлч ажилласан зарим төвд зөврийн компьютер бусад тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн.			√	
70.	Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний аргачлалын төслийг боловсруулж, талуудын саналыг тусган сайжруулж, ХНХСайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.			√	
71.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах “Нийгмийн хөгжилд эрчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганыг 2022 оны 1 дүгээр улиралд зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалыг бэлтгэж, батлууллаа.			√	
72.	“Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл” болон “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг ГХУСАЗЗ-ийн ажлын албанд хүргүүлэв.			√	
73.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргийн дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас 2021 онд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний талаарх тайлан, мэдээллийг ЖҮХ-нд хүргүүлэв.			√	
74.	НҮБ-ын ХАС, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн 2021 оны тайланг бэлтгэн НҮБ-ын ХАС-нд хүргүүлсэн. Мөн 2022 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлууллаа.			√	
75.	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг түшиглэн байгуулагдсан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалан байрлуулж, үйлчилгээ үзүүлдэг ТББ-ыг санхүүжүүлэхдээ Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу ХХҮЕГ-ын тушаалаар батлагддаг аргачлалд холбогдох заалтыг тусгаж өгөх талаар санал хүргүүлэв.			√	

76.	Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн хуралд оролцож, 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлээ.			√	
77.	Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэлтэй ажилгүй иргэн, ажил хайгч иргэний 2019.01-2021.12 сарын мэдээг нэгтгэв.			√	
78.	ҮСХ-ноос Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын асуулгын маягтад санал боловсруулж болон тооллогын комисст ажиллах удирдах албан тушаалтны нэрсийг цахимаар болон албан бичгээр хүргүүлэв.				
79.	Хүүхдийн статистикийн аргачлал, маягт, түүнийг нөхөх заавар болон Залуучуудын маягт, түүний нөхөх зааврыг боловсруулах талаар ҮСХ, ГБХЗГ, ГБХЗХГ, дотоодын зөвлөхүүд уулзалт зохион байгуулж, шинэ ажлын хэсгийн гишүүдийг эхний байдлаар тохирч тушаалын төсөл, удирдамжийг боловсруулав.			√	
80.	Засгийн газрын хэвлэл, мэдээллийн албаны зөвлөмжийн дагуу цахим хуудасны үндсэн цэс, толгой болон хөл(header& footer)-ний загварыг өөрчлөв.			√	
81.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт гүйцэтгэлийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээний цахим системийг нэвтрүүлэх талаар 2 удаагийн уулзалтыг зохион байгуулав.			√	
82.	Орлогыг орлуулан тооцох аргачлал шинэчлэгдэж байгаатай холбогдуулан аргачлалын төсөлд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуультай нийцүүлэн төрийн байгууллагын бусад мэдээллийн сантай тулгах асуудлаар санал өгөв.			√	
83.	АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ын хүрээнд мэдээллийн технологийн зөвлөхүүд болон худалдан авалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны тушаалын төслийг боловсруулав.			√	